Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежментийн систем

Нийгмийн менежментийн төлөвлөгөө

ГАРЧИГ ДУГААР **ХУУДАСНЫ**

1. ТАНИЛЦУУЛГА 4

1.1 Зорилго 4

1.2 Үйлчлэх цар хүрээ 4

1.3 Хэрэгжүүлж эхлэх хугацаа 4

1.4 Эрх хэмжээ ба удирдлага 4

2 ХАМРАХ ХҮРЭЭ 5

2.1 Менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ 5

2.2 Менежментийн бусад төлөвлөгөөтэй давхцах байдал 5

3 ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА 5

3.1 Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол үүрэг, хариуцлага 5

3.2 Голлон хариуцах талууд 6

4 ТӨСЛИЙН СТАНДАРТУУД 7

4.1 Монгол Улсын холбогдох хууль тогтоомж 7

4.2 Монгол Улсын үндэсний стандартууд 7

4.3 БОНБНҮ-ний шаардлагууд 7

4.4 Монгол Улсын хүлээсэн бусад үүрэг, Монгол Улсын холбогдох төрийн байгууллагын зүгээс тавьдаг шаардлагууд 8

4.5 Олон улсын холбогдох стандарт, удирдамжууд 9

4.6 Сентерра компанийн холбогдох бодлогын баримт бичгүүд 10

4.7 Бороо Гоулд Компанийн журмууд 10

4.8 Гацууртын төслийн хүрээнд дагаж мөрдөхөөр үүрэг хүлээсэн салбарын бусад удирдамжууд 10

5 ЭРСДЭЛ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ БА МЕНЕЖМЕНТИЙН ХЯНАЛТ 10

5.1 Хураангуй 10

5.2 Төлөвлөгөөний зорилго, зорилтууд 11

5.3 Гол оролцогч талууд 11

5.4 Менежментийн хяналт 11

6 ХЭРЭГЖИЛТИЙН ХУВААРЬ 39

6.1 Менежментийн төлөвлөгөөг хянан нягталж, шинэчлэх 39

7 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ 39

7.1 Хяналт-шинжилгээний шаардлагуудын тойм 39

7.2 Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд 39

8 СУРГАЛТ 40

9 АУДИТ БА ТАЙЛАГНАЛ 40

9.1 Дотоод аудит 40

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

9.2 Хөндлөнгийн аудит 40

9.3 Бүртгэл, тэмдэглэл хөтлөх 40

ХҮСНЭГТҮҮД

Хүснэгт 1: Гол үүрэг, хариуцлага 5
Хүснэгт 2: Менежментийн үндсэн хяналтын аргууд 12
Хүснэгт 3: Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт ба хяналтын арга хэмжээ 39

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

1. ТАНИЛЦУУЛГА

1.1 Зорилго

Сентерра Гоулд ХХК (цаашид “Сентерра” гэх) энэхүү Нийгмийн менежментийн төлөвлөгөөг Гацууртын алтны төслийн талбайд хэрэгжүүлэхэд зориулж тусгайлан боловсруулав. Уг Менежментийн төлөвлөгөө нь Сентерра компанийн эзэмшлийн компани болох Бороо Гоулд Компаниар (цаашид “БГК” гэх) дамжуулан Гацууртын төслөө нийгмийн нөлөөллийн талаас нь удирдан зохион байгуулах аргачлалыг тоймлон тусгасан цуврал менежментийн төлөвлөгөөнүүдийн нэг хэсэг юм. Уг менежментийн төлөвлөгөө дараах зорилгыг агуулж байна, үүнд:

- Менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээг тодорхойлж, менежментийн арга хэмжээнүүдийг харилцан уялдаатайгаар хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий талуудыг тогтоох;
- Үүрэг, хариуцлагыг тодорхойлох;
- Уг менежментийн төлөвлөгөөнд баримталбал зохих Төслийн стандартуудыг тоймлон тусгах;
- Энэхүү төлөвлөгөөнд хамааралтай Төслийн үүрэг, үйл ажиллагааны журам болон удирдамжийг тодорхойлох;
- Хяналт шинжилгээ, тайлагнах журмууд, тэр дундаа гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлох;
- Сургалтад тавих шаардлагыг тодорхойлох;
- Дагалдах материал, мэдээллийн лавлагааг зааж өгөхөд тус тус оршино.

1.2 Үйлчлэх цар хүрээ

Менежментийн төлөвлөгөөнд заасан шаардлагууд нь Гацуурт төслийн бүхий л үйл ажиллагаа болон төслийн бүх ажилтнууд, тэр дундаа гэрээт гүйцэтгэгчдэд мөн адил үйлчилнэ. Төлөвлөгөөнд тусгасан шаардлагуудыг Гацуурт төслийн олборлолт, хүдэр тээвэрлэлт болон Бороогийн алтны уурхай дахь боловсруулалт зэрэг Төслийн бүхий л үйл ажиллагаанд баримтална.

Тус төлөвлөгөө нь Сентерра компанийн Монголд явуулж буй бүх үйл ажиллагаанд баримталдаг, тэр дундаа БГК-д хэрэгжүүлдэг Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны менежментийн систем (ЭМААБОМС)-д үндэслэсэн бөгөөд Гацууртын төслийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежментийг ерөнхий удирдамжаар хангана. БГК-ийн ЭМААБОМС -нд өөрчлөлт орвол энэхүү төлөвлөгөөнд зохих өөрчлөлт хийх болно.

1.3 Хэрэгжүүлж эхлэх хугацаа

Менежментийн төлөвлөгөөг Гацууртын төслийн барилгын үе шатнаас эхлэн хэрэгжүүлнэ.

1.4 Эрх хэмжээ ба удирдлага

Төслийн барилгын болон ашиглалтын эхний үед уг төлөвлөгөөг хамгийн багадаа хагас жилд (зургаан сар тутам) нэг удаа хянах ба цаашдаа жилдээ нэг удаа төслийн хэрэгжилт, мөн журамд орсон өөрчлөлтөд нийцүүлэхийн тулд өөрчлөлт хийх шаардлагатай эсэхийг тодорхойлж байх юм. Төслийн зураг төсөл, процедурт орсон өөрчлөлтийг тусгах үүднээс илүү ойрхон давтамжтайгаар шинэчлэх хэрэгцээ үүсэхээс бусад тохиолдолд Менежментийн төлөвлөгөөнд ямар нэг өөрчлөлт, шинэчлэлт хийх шаардлагатай эсэхийг тогтоох зорилгоор хоёр жилд нэг удаа хянан нягтална.

Энэхүү менежментийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах шаардлага гарсан тохиолдолд хүсэлтийг уг менежментийн төлөвлөгөөг хариуцсан менежерт хүргүүлж зохих журмын дагуу хянаж, шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулж батална.

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

2 ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ

Энэхүү Менежментийн төлөвлөгөө нь Гацууртын уурхай дахь барилга, ашиглалт, уурхайн тээвэрлэлт, Бороогийн алтны уурхай дахь хүдэр боловсруулалт, тэр дундаа гэрээт гүйцэтгэгчдийн үйл ажиллагаанд мөн адил хамаарна.

2.2 Менежментийн бусад төлөвлөгөөтэй давхцах байдал

Энэхүү Менежментийн төлөвлөгөө нь Гацуурт төсөлд зориулан боловсруулсан багц Менежментийн Төлөвлөгөөнүүдийн нэг хэсэг бөгөөд Бороо гоулд уурхайд ашиглаж буй ЭМААБОМС-д заасан дараах төлөвлөгөөтэй уялдаж байна, тухайлбал:

- Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө;
- Гадаргын усны менежментийн төлөвлөгөө;
- Хүчиллэг чулуулгийн урсацын менежментийн төлөвлөгөө;
- Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө;
- Гацууртын уурхайн хаалтын төлөвлөгөө;
- БГК-ийн хаягдлын менежментийн байгууламжийн зааварчилгаа.

3 ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

3.1 Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол үүрэг, хариуцлага

Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол үүрэг, хариуцлагыг дор тоймлон харуулав.

Хүснэгт 1: Гол үүрэг, хариуцлага

Хариуцагч	Хариуцлага
БГК-ийн Ерөнхий менежер	Төслийн стандартууд болон энэхүү Төлөвлөгөөнд заасан бусад шаардлагуудад нийцсэн үйл ажиллагаа явуулахыг ханган ажиллах. Төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцийг батлах.
БГК-ийн Гадаад харилцаа эрхэлсэн захирал	Төлөвлөгөөний хамрах хүрээ, хэрэгжилтийг ерөнхийд нь хариуцах. Төлөвлөгөөг боловсруулах, хянах, шаардагдах өөрчлөлтүүдийг тусгах.
Орон нутгийн харилцааны менежер Хэвлэл мэдээллийн харилцаа хариуцсан менежер Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй хариуцсан менежер Уурхайн менежер Засгийн газартай харилцах менежер Хүний нөөцийн менежер	Үйл ажиллагаа эрхэлсэн хэлтсүүд, хэрэгжүүлэгч байгууллагууд, бусад оролцогч талуудтай хамтран Төлөвлөгөөг товлосон хугацаанд нь хэрэгжүүлэх. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнах. Төлөвлөгөөнд тусгагдсан шаардлагуудыг ахлах мэргэжилтнүүд, ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч нарт мэдээлэн таниулж, байнгын мэдээлэлтэй байх явдлыг ханган ажиллах.

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Хариуцагч	Хариуцлага
Ханган нийлүүлэлтийн сүлжээ/худалдан авах ажиллагааны менежер	
Орон нутгийн харилцааны ажилтнууд	Тухайн орон нутагт амьдардаг иргэд, идэвхтнүүдтэй шууд харилцаа холбоо тогтоож ажиллах. Тухайн орон нутагт мэдээллээр хангах, зөвлөлдөх хурал, уулзалт зохион байгуулахад шаардагдах ложистик буюу материал, техникийн хангамж зэргийг уялдуулан зохицуулах. Компанид хамааралтай асуудлаар орон нутгийн иргэдтэй харилцаж зөвлөлдсөн тохиолдлуудыг бүртгэж тэмдэглэл хөтлөх. Нөлөөлөлд өртсөн бүсэд орон нутаг, иргэдтэй харилцах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагааны талаар сар тутмын тайлан гаргаж танилцуулах. Хамтарсан ажлын хэсгийн хурал, уулзалтуудад оролцох.
Гэрээт гүйцэтгэгчид	Сентеррагийн болон БГК-ийн бодлого, журмуудад нийцсэн үйл ажиллагаа явуулах Хууль, журмын шаардлагуудын дагуу гэрчилгээ ба/эсвэл тусгай зөвшөөрлийг авах Нийгмийн нөлөөллийн менежментийн талаарх БГК-ийн шаардлагуудыг биелүүлэх. Холбогдох удирдлага, эсвэл удирдах эрх бүхий байгууллагад нийгмийн бодит болон болзошгүй бүхий л нөлөөллийн талаар тайлагнах
Ажиллагсад	Боломжийн хэрээр өөрсдийн үйл ажиллагаанаас орон нутагт үзүүлэх нөлөөллийг багасгах Гацуурт төслийн холбогдох бусад байгаль орчны болон нийгмийн бодлого, журам, мөн уг Менежментийн Төлөвлөгөөнд заасан үүрэг, хариуцлагыг биелүүлэх Холбогдох удирдлага, эсвэл удирдах эрх бүхий байгууллагад нийгмийн бодит болон болзошгүй бүхий л нөлөөллийн талаар тайлагнах

3.2 Голлон хариуцах талууд

Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг голлон хариуцах талуудыг (өөрөөр хэлбэл, энэхүү төлөвлөгөөний бүрдэл хэсгүүдийг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага бүхий албан тушаалтан, алба, хэлтсүүд) дор дурдав, үүнд:

- Үйл ажиллагаа эрхэлсэн ерөнхий менежер - ялангуяа аюулгүй байдлыг хангах менежмент, талбайгаас гадуурх үйл ажиллагааны аюулгүй байдлыг ханган хэрэгжүүлэх;
- Байгаль орчны менежер - хаягдал зайлуулах, утаа ялгаралт, аюултай материал болон газрын менежмент зэрэг олон нийт, орон нутгийн иргэдэд нөлөөлөл үзүүлж болзошгүй байгаль орчны асуудлаар мэдээлэл өгөх, таниулах;
- Уурхайн менежер – Гацууртын уурхайн ерөнхий менежментийн тухайд;
- Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй хариуцсан менежер - уурхай дотор болон гаднах орчинд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хяналтыг дотоод, гадаад аль аль талаас нь үр дүнтэй хэрэгжүүлэх;
- Хүний нөөцийн менежер - хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар;

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

- Хэвлэл мэдээллийн харилцаа хариуцсан менежер - оролцогч талуудтай харилцах, гол чухал мэдээллүүдийг олон нийтэд хүргэх, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй харилцах зэрэг холбогдох бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;
- Ханган нийлүүлэлтийн сүлжээ хариуцсан менежер – ханган нийлүүлэлт болон орон нутгийн бэлтгэн нийлүүлэгчидтэй харилцах харилцааны тухайд;
- Засгийн газартай харилцах менежер – хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй харилцах, орон нутгийн харилцаа болон Засгийн газрын харилцаа хариуцсан мэргэжилтнүүдийг удирдах, Засгийн газар, аймаг, сумдын албан тушаалтнуудтай харилцаа холбоотой ажиллах.

4 ТӨСЛИЙН СТАНДАРТУУД

Холбогдох стандартуудыг (“Төслийн стандартууд”) Төслийн бүхий л үйл ажиллагаанд баримтална.

4.1 Монгол Улсын холбогдох хууль тогтоомж

Энэхүү Төлөвлөгөөнд баримталбал зохих Монгол Улсын хууль тогтоомжоос дурдвал:

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (1998 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж, 2001, 2006, 2012 онуудад нэмэлт өөрчлөлт орсон);
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995 оны6-р сарын 5-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж, 2012 оны 5-р сарын 17-нд нэмэлт өөрчлөлт орсон);
- Газрын хэвлийн тухай хууль (1988 оны 11-р сарын 29-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа);
- Ашигт малтмалын тухай хууль (2006 оны 6-р сарын 26-нд хүчин төгөлдөр болсон);
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль (2001 оны 6-р сарын 8-нд хүчин төгөлдөр болж, 2004 онд нэмэлт өөрчлөлт орсон*)*;
- Хөдөлмөрийн тухай хууль (1999 оны 5-р сарын 14-нд хүчин төгөлдөр болж, 2012 оны 12-р сарын 13-нд нэмэлт өөрчлөлт орсон*)*;
- Ариун цэврийн тухай хууль (1998 оны 5-р сарын 7-нд хүчин төгөлдөр болсон*)*.

4.2 Монгол Улсын үндэсний стандартууд

Энэхүү НМТ-нд Монгол Улсын дараах стандартуудыг (MNS) мөрдөнө, үүнд:

- MNS 900:2005 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ.
- MNS 4990:2000. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага. MNS 3473:1983 Байгаль хамгаалал. Газар. Газар эдэлбэр. Газар ашиглалт. Нэр томьёо, тодорхойлолт.

4.3 БОНБНҮ-ний шаардлагууд

Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шаардагдах Төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнүүд (БОНБНҮ)-эд байгаль орчны менежмент, хяналтад тавигдах шаардлагыг тоймлон тусгасан болно. БОНБНҮ-нд тусгагдсан дор дурсан үүргүүд энэхүү менежментийн төлөвлөгөөнд мөн адил хамаарна. Үүнд:

- БИОИСЭЛДҮҮЛЭЛТИЙН® үйлдвэрийн БОНБНҮ (Натур Фрейндли ХХК, 2010);
- Гацууртын хүдэр тээвэрлэх замын БОНБНҮ (Газар Эко, 2006*)*;
- Гацууртын уурхайн БОНБНҮ *(*Натур Фрейндли ХХК, 2009), Гацууртын уурхайн БОНБНҮ-ний нэмэлт тодотголын тайлан *(*Эко Трэйд ХХК, 2014*)*.

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

4.4 Монгол Улсын хүлээсэн бусад үүрэг, Монгол Улсын холбогдох төрийн байгууллагын зүгээс тавьдаг шаардлагууд

Монгол Улс олон улсын хэд хэдэн гэрээ, хэлэлцээрт нэгдэж, тэдгээрт заасны дагуу зарим үйлдлийг хийх эсвэл хийхээс татгалзах үүрэг хүлээсэн билээ. Монгол Улсын Засгийн газар соёрхон батлсан олон улсын гэрээ, хэлэлцээрүүдээ хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой хуулиуд батлсны зэрэгцээ үндэсний хууль тогтоомжиндоо “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэсэн заалтыг оруулсан байдаг. Тиймээс Монгол Улсын нэгдэж орсон эдгээр олон улсын гэрээний нөхцлүүдийг ойлгох нь чухал юм. Гацуурtын төслийн нийгмийн менежментэд баримталбал зохих олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн товч хураангуйг дор тусгав.

- Хөдөлмөрийн харилцаа ба ажилчдын эрх:
    - Албадан хөдөлмөрийн тухай конвенц, 1930 (№29), 2005 оны 3-р сарын15-нд соёрхон батлсан;
    - Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай конвенц, 1948 (№87), 1969 оны 6-р сарын 3-нд соёрхон батлсан;
    - Зохион байгуулах, хамтын хэлэлцээ хийх эрхийн тухай конвенц, 1949 (№98), 1969 оны 6-р сарын 3-нд соёрхон батлсан;
    - Тэгш шан хөлс олгох тухай конвенц, 1951 (№100), 1969 оны 6-р сарын 3-нд соёрхон батлсан;
    - Эхчүүдийн эрхийг хамгаалах тухай конвенц (шинэчлэн найруулсан), 1952 (№103), 1969 оны 6-р сарын 3-нд соёрхон батлсан;
    - Албадан хөдөлмөрийг устгах тухай конвенц, 1957 (№105), 2005 оны 3-р сарын15-нд соёрхон батлсан;
    - Ялгаварлан гадуурхахгүй байх *(*хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжил) тухай конвенц, 1958 (№111), 1969 оны 6-р сарын 3-нд соёрхон батлсан;
    - Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай конвенц, 1964 (№122), 1976 оны 11-р сарын 24-нд соёрхон батлсан;
    - Хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарын тухай *(*газар доорхи ажил*)* конвенц, 1965 (№123) Хөдөлмөр эрхлэх насны тусгайлан заасан доод хязгаар: 18 нас, 1981 оны 12-р сарын 3-нд соёрхон батлсан;
    - Ажилчдын төлөөлөгчдийн тухай конвенц, 1971 (№135), 1996 оны 10-р сарын 8-нд соёрхон батлсан;
    - Хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарын тухай конвенц, 1973 (№138) Хөдөлмөр эрхлэх насны тусгайлан заасан доод хязгаар: 15 нас, 2002 оны 12-р сарын 16-нд соёрхон батлсан;
    - Гурван талт зөвлөлдөөний (олон улсын хөдөлмөрийн стандартууд) тухай конвенц, 1976 (№144), 1998 оны 08-р сарын 10-нд соёрхон батлсан;
    - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай конвенц, 1981 (№155), 1998 оны 2-р сарын 3-нд соёрхон батлсан;
    - Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээлт, ажил эрхлэлтийн (хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс) тухай конвенц, 1983 (№159), 1998 оны 2-р сарын 3-нд соёрхон батлсан.

- Мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл:
    - Ази, Номхон далайн бүсийн амьтны гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэл, эрүүл ахуйн комисс байгуулах тухай гэрээ (Монгол Улсад 2007 оны 5-р сарын 8-нд хүчин төгөлдөр болсон).

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

- Соёлын өв:
    - Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай конвенц (1964 онд соёрхон баталсан);
    - Соёлын үнэт зүйлийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенц (1991 онд соёрхон баталсан);
    - Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенц (1990 онд соёрхон баталсан);
    - Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенц (2005 онд соёрхон баталсан);
    - Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон дэмжих тухай конвенц (2005 онд соёрхон баталсан).
- Дүрэм, журмууд:
    - Монгол Улсын нутаг дэвсгэрт археологи, палеонтологийн хайгуул, малтлага, судалгаа хийх журам;
    - Иргэн, аж ахуйн нэгжийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булах үйл ажиллагааг үнэлэх, санхүүжүүлэх журам;
    - Агаарын чанарын мэдээлэл гаргах журам;
    - Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам;
    - Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, чанарын хянан баталгаа хийх, тайлагнах журам;
    - Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам.

4.5 Олон улсын холбогдох стандарт, удирдамжууд

Олон улсын стандартчиллын байгууллагаас байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тухай өргөн хүрээтэй хүлээн зөвшөөрөгдсөн цуврал стандартуудыг баталсан байдаг бөгөөд эдгээрээс Сентерра компани дор дурдсан стандартыг дагаж мөрддөг, тухайлбал.

- ISO14001:2004 Байгаль орчны удирдлагын тогтолцоо
- OHSAS 18001 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо.

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ЕСБХБ):

ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлого (2014 оны 5-р сар)-ын дагуу байгаль орчин, нийгмийн асуудлуудад үнэлгээ болон хяналт-шинжилгээ хийх замаарр санхүүжүүлж буй төслүүддээ дараах шаардлагыг тавидаг, тухайлбал:

- Байгаль орчин, нийгмийн талаасаа тогтвортой байх;
- Нөлөөлөлд өртөж болзошгүй ажилчид болон орон нутгийн иргэдийн эрхийг хүндэтгэх;
- Холбогдох хуулийн шаардлага, олон улсын сайн туршлагад нийцүүлэн аливаа төслийг боловсруулж хэрэгжүүлэх.

ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн талаарх гүйцэтгэлийн шаардлагуудаас дурдвал:

- ГШ 1: Байгаль орчны болон нийгмийн үнэлгээ ба менежмент;
- ГШ 2: Ажиллах хүчин ба хөдөлмөрийн нөхцөл;
- ГШ 3: Нөөцийн үр ашигтай хэрэглээ, бохирдлоос урьдчилан сэргийлэх ба багасгах;

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

- ГШ 4: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй;
- ГШ 5: Газар чөлөөлөх, албадан нүүлгэх ба эдийн засгийн шилжилт хөдөлгөөн;
- ГШ 6: Биологийн олон янз байдлыг хадгалах, амьд байгалийн нөөцийг тогтвортой ашиглах менежмент;
- ГШ 7: Нутгийн уугуул иргэд;
- ГШ 8: Соёлын өв;
- ГШ 9: Санхүүгийн зуучлагчид;
- ГШ 10: Мэдээллийг ил тод болгох, сонирхогч талуудыг татан оролцуулах.

4.6 Сентерра компанийн холбогдох бодлогын баримт бичгүүд

Энэхүү Менежментийн төлөвлөгөөг Сентерра компанийн мөрддөг дор дурдсан бодлого, журмууд, тэр дундаа ажилчдын аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, байгаль орчныг хамгаалах болон тогтвортой хөгжлийг хангах бодлогын хүрээнд боловсруулав.

4.7 Бороо Гоулд Компанийн журмууд

СГМ-гийн бүхий л үйл ажиллагаа нь Бороогийн алтны уурхайд хэрэгжиж байгаа БГК-ийн ЭМААБОМС-ийн шаардлагуудын дагуу явагдана.

4.8 Гацууртын төслийн хүрээнд дагаж мөрдөхөөр үүрэг хүлээсэн салбарын бусад удирдамжууд

Сентеррагийн дагаж мөрдөх үүрэг хүлээсэн салбарын бусад удирдамжуудаас дурдвал:

- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОҮИТБС) (Сентерра компани уг санаачлагад нэгдэн орсон);
- Даяар тайлагнах санаачлага (ДТС, GRI)-ын G3 индекс, мөн “Уул уурхай, металлын нэмэлт” салбарын удирдамж;
- Аюулгүй байдал, хүний эрхийн сайн дурын зарчмууд;
- Дэлхийн алтны зөвлөлөөс баталсан “Зэвсэгт мөргөлдөөн, хүний эрхийн зөрчлөөс ангид улс орнуудаас алт олборлох” стандарт;
- Цианидын менежментийн олон улсын стандарт болох Цианидын Код (алт олборлогч, цианид илгээгч, тээвэрлэгч болохын хувьд), (Сентерра одоогоор уг стандартад нэгдэн орсон бөгөөд цаашид уг батламжаа баталгаажуулж ажиллах болно).

5 ЭРСДЭЛ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ БА МЕНЕЖМЕНТИЙН ХЯНАЛТ

5.1 Хураангуй

Гацууртын төслөөс шууд болон шууд бусаар үүсч болзошгүй нийгмийн эрсдлүүдийг бууруулахаар хүлээсэн үүрэг, ажлын арга барилыг энэхүү баримт бичигт тоймлон тусгав.

Гацууртын төслийн нийгмийн нөлөөллийн менежментийг зохистой байдлаар хийхэд уг Менежментийн төлөвлөгөөний зорилго оршиж байна. Монгол Улсын болоод олон улсын холбогдох стандартуудын дагуу, Төслийн нийгэмд үзүүлэх эрсдлийг доод түвшинд хүргэж бууруулах, үр шимийг нь аль болох нэмэгдүүлэхэд чиглэсэн менежментийн хяналт хэрэгжүүлэх арга замаар эл зорилтоо хангана.

Гацууртын төслийн менежментийн үндсэн хяналтын арга хэмжээнүүдийг Хүснэгт 2-т тусгав.

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

5.2 Төлөвлөгөөний зорилго, зорилтууд

Нийгмийн нөлөөллийн менежментийн ерөнхий зорилго нь сөрөг нөлөөлөл үүсч болзошгүй тохиолдолд түүнээс зайлсхийх, хэрэв зайлсхийх бодит боломжгүй бол нөлөөллийг доод түвшинд хүргэхэд оршино. Эерэг нөлөөлөл үзүүлэх тохиолдолд уг нөлөөллийг аль болох нэмэгдүүлэхэд зорьж ажиллана. Эдгээр зорилго, зорилтоо дараах арга замаар хангана. Үүнд:

- Эрсдэлд үндэслэн нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдахад тэргүүлэх чиглэл буюу хамгаас чухалчлах хүчин зүйлсийг тодорхойлох;
- Нийгэмд сөрөг нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх, эсвэл уг нөлөөллийг доод түвшинд хүргэж бууруулах;
- Нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллийг аль болох нэмэгдүүлэх;
- Боломжтой тохиолдол бүрт инженерчлэлийн хяналтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Үлдэгдэл эрсдлийг бууруулахад чиглэсэн менежментийн хяналтыг хэрэгжүүлэх;
- Осол зөрчил гарсан тохиолдолд эрсдэлд суурилсан онцгой байдлын менежментийн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Энэхүү Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх замаар эдгээр зорилтоо биелүүлэхийг эрмэлзэн ажиллаж, 7.2 дахь хэсэгт нарийвчлан тусгасан Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг ашиглан үнэлэлт, дүгнэлт хийнэ.

5.3 Гол оролцогч талууд

Энэхүү төлөвлөгөөнд хамаарал бүхий гол оролцогч талуудаас дор дурдав (дэлгэрэнгүй тодорхойлолтыг Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөнөөс үзнэ үү):

Оролцогч тал	**Сонирхол/харилцан холбоотой ажиллах чиглэл**
Монгол Улсын Засгийн газар	Төсөлд зөвшөөрөл, батламж олгох, хяналт тавих.
Төрийн бус байгууллагууд (ТББ), Олон нийтийн оролцоонд түшиглэсэн байгууллагууд (ОНОТБ)	Орон нутгийн хөгжил, Компанийн нийгмийн хариуцлага; тодорхой асуудалтай холбоотой сонирхол
Судалгааны болон эрдэм шинжилгээний байгууллагууд	Хууль тогтоомж, дүрэм журмын биелэлт, тайлагнал
Нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд	Төслийн нөлөөлөлд шууд ба шууд бусаар өртсөн бүлэг хүмүүс.

5.4 Менежментийн хяналт

Нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээнд тодорхойлсон нөлөөлөл болон боломжуудад үндэслэн Хүснэгт 2-т дэлгэрэнгүй тусгасан хяналтын арга хэмжээнүүдийг Гацуурт төслийн барилга, ашиглалт, хаалтын үе шатуудад авч хэрэгжүүлнэ.

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Хүснэгт 2: Менежментийн үндсэн хяналтын аргууд

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
НМТ01	Эдийн засаг	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Орон нутгийг хөгжүүлэх хамтын ажиллагааны гэрээ (ОНХХАГ)-нд заасны дагуу Нийгмийн хөгжлийн сангийн хэрэгжилтэд удирдамж болгох Орон нутгийн хөгжлийн менежментийн төлөвлөгөө боловсруулах.	Байгаль орчны менежер Засгийн газартай харилцах асуудал хариуцсан менежер Орон нутгийн харилцааны менежер Орон нутгийн харилцааны ажилтнууд	• Дотоод аудит, хяналтын хөтөлбөр.

НМТ02	Эдийн засаг		• ОНХХАГ-ний хүрээнд тусгай хөтөлбөрүүдийг тодорхойлохын тулд сонирхогч болон оролцогч талуудыг татан оролцуулах, ингэхдээ орон нутгийг хөгжүүлэх тодорхой санал санаачлагуудын талаар санал бодлыг нь авах; үүнийг Төслийн ашиглалтын үе шатанд туршилтын журмаар хэрэгжүүлж улмаар уурхайн хаалтын үе шатанд шилжихтэй зэрэгцэн өргөн хүрээгээр хэрэгжүүлэх боломжтой. Ингэхдээ дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ, үүнд:
			  ○ ОНХХАГ-ний хүрээнд бичил санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагатай түншлэл бий болгох.
			  ○ Тухайн санхүүгийн жилд зорилтот газар нутагт хэрэгжүүлэх хөтөлбөрийн дагуу хандив тусламж олгох хуваарь гаргах
				Орон нутгийн харилцааны менежер
				Орон нутгийн харилцааны ажилтнууд
					• ОТТОТ;
					• Орон нутгийн иргэд/ оролцогч талуудын санал, дүгнэлт (Өргөдөл, гомдол шийдвэрлэх журам)
					• Дотоод аудит, хяналтын хөтөлбөр.

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
			○ Тэтгэлэгт хөтөлбөрийн бүрдэл хэсгүүдийг нэвтрүүлж, ОНХХАГ-ний хүрээнд дэх хандив тусламжийг халах; ○ ОНХХАГ-ний хүрээнд хийх хөрөнгө оруулалтыг илүү тогтвортой үр дүнд хүргэхийн тулд (хөрөнгийн зардал, дэд бүтэц гэхээс илүүтэй) хүмүүст чиглэсэн хөрөнгө оруулалт руу түлхүү чиглүүлэх		
НМТ03	Эдийн засаг	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Аймаг болон төслийн талбай байрлах сумдуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу орон нутгийг хөгжүүлэх арга хэмжээнүүдийг дор дурдсанд зарчимд нийцүүлэн авч хэрэгжүүлэх. Үүнд: • ОНХХАГ-ний дагуу санхүүжүүлэх арга хэмжээнүүдийг аймгийн болон орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгах; • Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн зорилго тогтвортой хөгжлийн зарчмуудад үндэслэсэн байх; • Хөрөнгө оруулалтын хөтөлбөр иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл болон өрхийн бизнесийг дэмжихэд чиглэсэн байх.	Орон нутгийн харилцааны менежер Орон нутгийн харилцааны ажилтнууд	• Дотоод аудит, хяналтын хөтөлбөр • Орон нутгийн иргэд/ оролцогч талуудын санал, дүгнэлт (Өргөдөл, гомдол шийдвэрлэх журам) • Нийгмийн суурь үнэлгээнд хийх байнгын хяналт-шинжилгээ
НМТ04	Эдийн засаг	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Орон нутгаас бараа үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохицуулах үүднээс Орон нутгийн худалдан авалтын бодлого, менежментийн төлөвлөгөөг ОНХХАГ-нд заасны дагуу хэрэгжүүлнэ. Үүнд: • Орон нутаг дахь үнийн өсөлтөөс үүдэлтэй нөлөөллийг доод түвшинд барихын тулд төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй сум/ багуудаас худалдан авалт хийх.	Ханган нийлүүлэлтийн сүлжээ/худалдан авах ажиллагааны менежер Хүний нөөцийн менежер Орон нутгийн харилцааны менежер	• Орон нутгийн худалдан авалтын бодлого • Орон нутгийн худалдан авалтын менежментийн төлөвлөгөө • Бэлтгэн нийлүүлэгчдийн гэрээний бүртгэл

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
			• Чанар, хэмжээ, тоо ширхэг жигд байх зэрэг шалгуур, үзүүлэлтүүдэд БГК-иас тавьдаг техникийн тодорхойлолт, шаардлагуудыг тодорхой тайлбарлан таниулахын зэрэгцээ бэлтгэн нийлүүлэгчидтэй байгуулах гэрээнд эдгээр шаардлага, бараа бүтээгдэхүүн хүргэх, үйлчилгээ үзүүлэхэд тавих зохих стандартуудыг ойлгомжтой, тодорхой байдлаар тусгайлан заах; • Сонгогдох магадлалтай орон нутгийн бэлтгэн нийлүүлэгчдийг шигших зорилгоор гэрээний эрх олгохын өмнөх судалгаа хийх; • Орон нутгаас татан авалт хийх, бараа үйлчилгээ худалдан авах боломжийг орон нутгийн бэлтгэн нийлүүлэгчдэд олгох үүднээс Бэлтгэн нийлүүлэгчдийн хөгжлийн хөтөлбөрөөр дамжуулан жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч-бэлтгэн нийлүүлэгчдийг сургалтад хамруулах, хөгжүүлэх зорилтот арга хэмжээ авч хэрэгжүүлэх; • Орон нутгийн ажилчид тухайн орон нутагтаа тодорхой хугацаанд оршин суусан байх шалгуурыг хангахтай нэгэн адилаар бэлтгэн “орон нутгийн бэлтгэн нийлүүлэгч” гэсэн шалгуурт тэнцэхийн тулд тухайн орон нутагтаа бизнес, үйлчилгээ эрхлэх гэсэн энгийн шаардлага тавигдана.	Орон нутгийн харилцааны ажилтнууд	• Гэрээний эрх олгохын өмнөх судалгааны бүртгэл • Сургалтын бүртгэл дэх бэлтгэн нийлүүлэгчдийн сургалтын талаарх бүртгэл, тэмдэглэл • Сургалтын менежментийн төлөвлөгөө.

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
НМТ05	Эдийн засаг	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Өсөн нэмэгдсэн татварын орлогыг үр дүнтэй, ил тод байдлаар удирдах, нийгмийн болон ахуйн үйлчилгээний эрэлт хэрэгцээ, ялангуяа орон нутаг дахь эмзэг бүлгүүдэд үзүүлэх төрийн үйлчилгээг үзүүлэх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн чадавхийг бэхжүүлэх санаачилгуудыг дэмжих. Ялангуяа орон нутгийн түвшинд эмзэг бүлгийнхнийг дэмжих, ОҮИТБС-ыг дэмжигч компанийн хувьд Сентарра компанийн хүлээсэн үүрэг, ДТС-ын тайлагналыг хэрэгжүүлэх, Монгол Улсыг үндэсний болоод олон улсын түвшинд хөрөнгө оруулалт хийхэд тохиромжтой орон болгож дэмжихэд онцгойлон анхаарч ажиллана.	Орон нутгийн харилцааны менежер Засгийн газартай харилцах асуудал хариуцсан менежер Хэвлэл мэдээллийн харилцаа хариуцсан менежер	• ОҮИТБС-ын тайлан • ДТС-ын тайлан • Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, харилцааны бүртгэл, тэмдэглэл • ОТТОТ.
НМТ06	Ажиллах хүчин ба хөдөлмөрийн нөхцөл	Бүх үйл ажиллагаанд хамаарна	• Монгол ажилчдад ажлын байрны аюулгүй байдлын олон улсын стандартуудад нийцэн ажиллах чадвар эзэмшүүлүүлэх зорилгоор Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд (МСҮТ)-тэй сургалтад тавигдах шаардлагын чиглэлээр уялдаатай ажиллах; • ОНХХАГ-нд заасны дагуу тухайн ажлын байрны шаардлагыг хангах ажил хайгч иргэдийг ажилд орох өргөдөл гаргахыг сайшаан дэмжих үүднээс сумын захиргаатай хамтран ажиллах.	Хүний нөөцийн менежер	• МСҮТ-тэй хийсэн хурал, уулзалтын протокол, тэмдэглэл • МСҮТ-тэй харилцан ойлголцлын санамж бичиг үзэглэх • Засгийн газрын холбогдох байгууллагатай хийсэн хурал, уулзалтын протокол, тэмдэглэл.
НМТ07	Ажиллах хүчин ба хөдөлмөрийн нөхцөл		• Ажлын байранд тавигдах шаардлагыг тодорхой заасан ажлын сул орон тооны талаарх мэдээллийг түгээх; • Орон нутгийн хөдөлмөр зуучлалын албадаар уламжлан сул орон тоог зарлах, СГМ-гийн цахим хуудсанд мөн зар тавих.	Хүний нөөцийн менежер	• Сул ажлын байрны орон тоо зарласан бүртгэл, тэмдэглэл.

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
HMT08	Ажиллах хүчин ба хөдөлмөрийн нөхцөл	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Орон нутгийн харилцаа хариуцсан багийнханд ард иргэдийг татан оролцуулах, гэрээр нь очиж биечлэн уулзах, төслийн нөлөөлөлд өртөх магадлалтай талуудтай хөдөлмөр эрхлэх боломж, тавигдах шаардлагууд, өргөдөл гаргах хугацаа, үнэлгээ хийх процессын тухай ярилцах чадварт нь дөхөм болохуйц байнгын сургалтаар хангах.	Хүний нөөцийн менежер Орон нутгийн харилцааны менежер	• Сургалт, ур чадварын бүртгэл • Хөдөлмөр эрхлэлт, сургалтын менежментийн төлөвлөгөө.
HMT09	Эдийн засаг	Уурхайн хаалт	• Ажилд авах магадлалтай гэж үзсэн ажил олгогчдыг судлах, ажилд авах орон тоо, чиг үүрэг, ажлын байрны тоог ажлаас халагдах ажилчдад мэдээлэх; • Хөдөлмөр эрхлэх бусад боломж/ бизнес хөгжүүлэх бусад боломжуудыг судлахад нь сумын захиргаанд дэмжлэг үзүүлэх; • Хамтын гэрээнд заасанчлан олноор нь цомхотгох тохиолдолд тавих шаардлагыг биелүүлэх;	Хүний нөөцийн менежер	• Хөдөлмөр эрхлэх бусад хувилбар, боломжуудын талаар мэдээлэх хуудас • Уурхайн хаалтын үед хөдөлмөр эрхлэх бусад хувилбар, боломжуудын талаар сумын захиргаатай харилцаж ажилласан тухай бүртгэл, тэмдэглэл • Олноор нь цомхотгох хэлэлцээний хэрэгжилтийн тухай тэмдэглэл, бүртгэл
HMT10	Ажиллах хүчин ба хөдөлмөрийн нөхцөл	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Сонгогдох магадлалтай ажилчдыг сургалтад хамруулах замаар шинэ ажилд бэлтгэх, ажил үүргээ биелүүлэх чадварыг бий болгоход нь дэмжлэг туслалцаа үзүүлэх.	Хүний нөөцийн менежер	• Сургалт, ур чадварын бүртгэл • Хөдөлмөр эрхлэлт, сургалтын менежментийн төлөвлөгөө.
HMT11	Ажиллах хүчин ба хөдөлмөрийн нөхцөл	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Оролцогч талуудтай үүсгэсэн харилцаа холбоог бэхжүүлэн хадгалах үүднээс ажил үүрэг, хариуцлагын зааг ялгаа тогтоох, түүнчлэн ажиллах хүчинд тавигдах шаардлага, хамрах хугацааны хязгаарыг тодорхой зааж тайлбарлах.	Хүний нөөцийн менежер	• Хөдөлмөр эрхлэлт, сургалтын менежментийн төлөвлөгөө.

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
HMT12	Ажиллах хүчин ба хөдөлмөрийн нөхцөл	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Бороогийн уурхайд ажиллаж байгаа Монгол иргэдийг байнгын сургалтаар хангах.	Хүний нөөцийн менежер	• Сургалт, ур чадварын бүртгэл • Хөдөлмөр эрхлэлт, сургалтын менежментийн төлөвлөгөө.
HMT13	Ажиллах хүчин ба хөдөлмөрийн нөхцөл	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Бороогийн уурхайд одоо ажиллаж байгаа/эсвэл урьд нь ажиллаж байсан ажилчдыг удирдах ажилд томилох (бололцооны хэрээр), шинэ ажилчдыг сургаж дадлагажуулах зэргээр ажиллуулах.	Хүний нөөцийн менежер	• Сургалт, ур чадварын бүртгэл • Хөдөлмөр эрхлэлт, сургалтын менежментийн төлөвлөгөө.
HMT14	Ажиллах хүчин ба хөдөлмөрийн нөхцөл	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Шинэ тоног төхөөрөмж (ялангуяа, БИОИСЭЛДҮҮЛЭЛТИЙН® үйлдвэрийн) ажиллуулах чадвар суулгах үүднээс боловсруулалтын цехийн ажилчдыг давтан сургалтад хамруулах.	Хүний нөөцийн менежер	• Сургалт, ур чадварын бүртгэл • Хөдөлмөр эрхлэлт, сургалтын менежментийн төлөвлөгөө.
HMT15	Ажиллах хүчин ба хөдөлмөрийн нөхцөл	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Гадаадын ажиллах хүчнийг хугацаат гэрээний үндсэн дээр ажиллуулах.	Хүний нөөцийн менежер	• Хөдөлмөр эрхлэлт, сургалтын менежментийн төлөвлөгөө • Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, тэмдэглэл.
HMT16	Ажиллах хүчин ба хөдөлмөрийн нөхцөл	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Төслийн бүхий л үе шат, бүрэлдэхүүн хэсэгт эрх тэгш, тууштай хэрэгжүүлэх үүднээс төслийн ажилчид, гэрээт гүйцэтгэгчдийн ажилчдыг мөн адил хамруулан хөдөлмөрийн гэрээ байгуулсан байх, үүнд хяналт тавьж, хэрэгжилтийг хангах. Ажиллагсдын зүгээс гомдол гаргах журам боловсруулж хэрэгжүүлэх	Ханган нийлүүлэлтийн сүлжээ/худалдан авах ажиллагааны менежер	• Хөдөлмөрийн гэрээний бүртгэл • Дотоод аудит, хяналтын хөтөлбөр • Ажилчдын зүгээс өргөдөл, гомдол гаргах журам, өргөдөл гомдлын бүртгэл

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
НМТ17	Ажиллах хүчин ба хөдөлмөрийн нөхцөл	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Гацуурtын төслийн ажилчид БГК-ийн ажилчдын үйлдвэрчний эвлэлийн нэг хэсэг байна гэж үзсэний үндсэн дээр БГК-ийн хөдөлмөрийн гэрээний загварыг СГМ-ийн нийт ажилчидтай хийх гэрээнд ашиглаж улмаар нэг мөр, тууштай хэрэгжилтийг хангана.	Хүний нөөцийн менежер	• Хөдөлмөрийн гэрээний бүртгэл
НМТ18	Ажиллах хүчин ба хөдөлмөрийн нөхцөл	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Бүх гэрээт гүйцэтгэгчид хамгийн наад зах нь Хөдөлмөрийн тухай хуулийг дагаж мөрдөх, тэр дундаа Хөдөлмөрийн хуульд зааснаас бусад Хамтын гэрээтэй холбоотой нэмэлт заалтуудыг хангасан байх шаардлага тавих; ЕСБХБ-ны ГШ 2 болон Хөдөлмөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг бүх гэрээт гүйцэтгэгчдээс шаардахын зэрэгцээ “Ажиллагчдын стандартын хэрэгжилтийг хянан нягтлах” тогтмол хэрэгжүүлнэ.	Хүний нөөцийн менежер Ханган нийлүүлэлтийн сүлжээ/худалдан авах ажиллагааны менежер	• Дотоод аудит, хяналтын хөтөлбөр • Хамтын гэрээний бүртгэл, тэмдэглэл.
НМТ19	Ажиллах хүчин ба хөдөлмөрийн нөхцөл	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Гэрээт гүйцэтгэгчид үйлдвэрчний эвлэлд элсээгүй байх тохиолдолд гэрээний биелэлтийг хангуулах механизмыг бий болгох үүднээс Гэрээт гүйцэтгэгчдийн менежментийн төлөвлөгөө боловсруулах	Хүний нөөцийн менежер Ханган нийлүүлэлтийн сүлжээ/худалдан авах ажиллагааны менежер	• Гэрээт гүйцэтгэгчдийн менежментийн төлөвлөгөө
НМТ20	Ажиллах хүчин ба хөдөлмөрийн нөхцөл	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Үнийн үсэлтээс үүдэлтэй нөлөөллийг бууруулах үүднээс цалин хөлсний хэмжээг хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц бөгөөд БГК-ийн тухайн үеийн цалин хөлстэй дүйцэхүйц хэмжээнд барих.	Хүний нөөцийн менежер	• Нийгмийн суурь үнэлгээнд хийх байнгын хяналт-шинжилгээний тайлан

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
НМТ21	Хүн ам зүй	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Сумын захиргаатай хамтран хүн ам зүйн өөрчлөлтөд ажиглалт судалгаа хийх, ялангуяа уурхайг дагасан иргэдийн шилжилт хөдөлгөөний улмаас гарах сөрөг нөлөөлөл, эсвэл уурхайн ажилчдын хоорондын, эсвэл уурхайн ажилчид болон орон нутгийн иргэдийн хооронд үүсэх харилцаанд хяналт-шинжилгээ хийх, улмаар шаардлагатай тохиолдолд зохих арга хэмжээ авах	Орон нутгийн харилцааны менежер	• Нийгмийн суурь үнэлгээнд хийх байнгын хяналт-шинжилгээний тайлан
НМТ22	Хүн ам зүй	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Барилгын богино хугацаанд ажилчдыг ажиллуулснаас үүсч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах үүднээс барилгын ажилчдын кемпэд баримталбал зохих жишиг журмыг дараах байдлаар мөрдүүлнэ. Үүнд: • Гэрээт гүйцэтгэгчдийн ажилчдаас ажлын талбайд болон кемпэд ажиллахдаа СГМ-ийн шаардлагуудыг биелүүлэхийг шаардах. • Бороо гоулд компаниас мансууруулах бодис, согтууруулах ундааны хэрэглээний талаар баримталдаг бодлого, мөн СГМ-гийн аюулгүй ажиллагааны шаардлагуудыг биелүүлэхийг Гэрээт гүйцэтгэгчдээс шаардах. • СГМ-гийн нэгэн адилаар юуны түрүүнд орон нутгийн иргэдээс ажилд авахыг анхаарахыг Гүйцэтгэгчдээс шаардах.	Ханган нийлүүлэлтийн сүлжээ/худалдан авах ажиллагааны менежер Хүний нөөцийн менежер Орон нутгийн харилцааны менежер Байгаль орчны менежер	• Дотоод аудит, хяналтын хөтөлбөр • Гэрээт гүйцэтгэгчдийн менежментийн төлөвлөгөө.
НМТ23	Хүн ам зүй	Бүх үйл ажиллагаанд хамаарна	• Төслөөс шалтгаалсан иргэдийн шилжилт хөдөлгөөний улмаас үүсэх асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх үүднээс Засгийн газартай харилцах; • Төслөөс шалтгаалан нийгмийн хэв журам алдагдах, харшилсан аливаа зан авир, үйл хөдлөл гарсан тохиолдолд СГМ цагдаагийн	Орон нутгийн харилцааны менежер Засгийн газартай харилцах асуудал хариуцсан менежер	• Хурал, уулзалтын протокол, тэмдэглэл • Нийгмийн суурь үнэлгээнд хийх байнгын хяналт-шинжилгээний тайлан Нийгмийн суурь үнэлгээнд

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
			байгууллага болон Засгийн газрын холбогдох агентлагуудтай хамтран ажиллаж тухайн асуудлыг шийдвэрлэнэ.		хийх байнгын хяналт-шинжилгээний тайлан
НМТ24	Газар ашиглалт, иргэдийн амьжиргаа	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Төслийн бүхий л үе шатанд тоосжилтыг бууруулах үүднээс замын тоос дарах арга хэмжээ авна. Авч хэрэгжүүлэх нэмэлт арга хэмжээнээс дурдвал: • Тодорхой давтамжтайгаар зам индүүдэх ажлыг нэмж хийх. • Ачааны машинаас тоос бургих, хүдэр асгарахаас сэргийлж ачааг бүтээх. • Оролцогч талуудын оролцоог хангах төлөвлөгөөнд тодорхойлсончлон ачааны машинуудын хөдөлгөөн, тоо, давтамж, тээвэрлэлт хийх цаг зэргийг мэдээлж байх. • Барилга угсралт, ашиглалт, хаалтын үе шатанд сайжруулсан хайрган замыг ашиглах хэмжээнд байлгах. Хаягдал хадгалах байгууламжийн өргүүрээс тоос дэгдэхийг багасгах дараах арга хэмжээ авах, үүнд: ○ Барилгын ажлыг цаг агаарын байдалд аль болон нийцүүлж төлөвлөх; шаардлагатай бол тухайн талбайд хэсэгчлэн тоос дарах арга хэмжээ авах; ○ Барилгын материал татах тээвэрлэлтийн давтамжийг аль доод түвшинд хүртэл багасгах; ○ Оролцогч талуудад мэдэгдэх, өргөдөл, гомдол шийдвэрлэх мерханизмыг бий болгох.	Байгаль орчны менежер Орон нутгийн харилцааны менежер Орон нутгийн харилцааны ажилтнууд Уурхайн менежер	• Агаар бохирдуулагч бодис, утаа ялгаралтын менежментийн төлөвлөгөө • ОТТОТ (Гомдол бүртгэх бүртгэл) • Нийгмийн суурь үнэлгээнд хийх байнгын хяналт-шинжилгээний тайлан • Оролцогч талуудад мэдэгдэл өгсөн тухай бүртгэл, тэмдэглэл.

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
НМТ25	Газар ашиглалт, иргэдийн амьжиргаа	Бүх үйл ажиллагаанд хамаарна	• ОНХХАГ-нд заасны дагуу Сумын хөгжлийн сангаар дамжуулан санхүүжүүлсэн үйл ажиллагаануудын хүрээнд бэлчээр, тариалангийн талбайг сайжруулах арга хэмжээнүүдийг гэрээний хүрээнд санхүүжилт олгохоор төлөвлөх. Үүнд: ○ Малчид, тариаланчдад малын эрүүл мэнд, ургацын чанарыг сайжруулах, мал сүрэг, тариалангийн менежментийг боловсронгуй болгох, улмаар амьжиргаагаа дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх; ○ Орлогын эх үүсвэр бий болгох, өргөжүүлэх зорилго бүхий малчид, тариаланчдын хамтын ажиллагааны санаачилгыг дэмжих; ○ Бэлчээр, мал аж ахуй болон нүүдлийн соёлыг хадгалан үлдээх.	Байгаль орчны менежер Орон нутгийн харилцааны менежер Орон нутгийн харилцааны мэргэжилтнүүд Ложистик буюу материал, техникийн хангамж хариуцсан менежер	• ОНХХАГ-ний хэрэгжилтийн бүртгэл • Нийгмийн суурь үнэлгээнд хийх байнгын хяналт-шинжилгээний тайлан
НМТ26	Хүн ам зүй бүрдэл	Бүх үйл ажиллагаанд хамаарна	• Одоо мөрдөж байгаа журмын дагуу СГМ-гийн харуул хамгаалалтын алба Гацууртын талбайд харуул, хамгаалалт хийж хууль бусаар мод бэлтгэгчдийг илрүүлсэн тохиолдолд талбайгаас гаргах.	Аюулгүй байдлын албаны менежер Орон нутгийн харилцааны менежер	• Аюулгүй байдлын асуудал/зөрчил гарсантохиолдлын бүртгэл
НМТ27	Хүн ам зүй	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Ландшафтад үзүүлэх нөлөөллийг дор дурдсан арга замаар бууруулах: • Ургамлан нөмрөгийг хуулах газрыг төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах талбайн хэмжээгээр хязгаарлах, • Гацууртын талбайн зүүн эцэс дэх нарийн хөндийн хөндлөн гулд аль болох их газрыг торлосон хамгаалалттай хэвээр байлгах. Бэлтгэл шуудуу гаргахаас үүдэн газар хөндөгдөх явдлыг бууруулахын тулд өдгөө	Байгаль орчны менежер	• ОТТОТ (Гомдол бүртгэх бүртгэл) • Газар чөлөөлөх, мал оторлуулах өвслөг газрыг нөхөн сэргээх журам • Нийгмийн суурь үнэлгээнд хийх байнгын хяналт-шинжилгээний тайлан

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
			бэлэн байгаа талбайг ашиглаж, шинээр газар хөндөх хэмжээг аль болох багасгах. Материал гаргаж авах ажил дууссаны дараа бэлтгэл шуудуунуудыг нөхөн сэргээнэ. Газар чөлөөлөх, мал оторлуулах өвслөг газрыг нөхөн сэргээх ажиллагаанд Бороогийн төсөлд хэрэгжүүлж үр дүнтэй гэдэг нь нотлогдсон процессуудыг баримтална.		
НМТ28	Хүн ам зүй		Өндөр үнэ цэнэтэй ой модот газруудыг хамгаалах үүднээс ургамлан нөмрөг хуулахыг дүйцүүлэн хамгаалах нь улирлын шинжтэй ажлын байр бий болгох, орон нутгийн иргэдэд орлогын эх үүсвэр бүрдүүлэх эерэг үр дагавартай. Түнхэл тосгоны иргэд нутгаасаа мод шилжүүлэн суулгасан туршлагын жишгээр ургамлан нөмрөг хуулсны нөлөөлөлд шууд өртсөн иргэдийг ажлын байраар хангах замаар энэхүү үр дүнг улам өргөжүүлнэ.	Байгаль орчны менежер Орон нутгийн харилцааны менежер Орон нутгийн харилцааны ажилтнууд	• Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө • Хөдөлмөр эрхлэлт, сургалтын менежментийн төлөвлөгөө • Орон нутгийг хөгжүүлэх менежментийн төлөвлөгөө • Нийгмийн суурь үнэлгээнд хийх хяналт-шинжилгээний тайлан
НМТ29	Хүн ам зүй	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Уурхайн хаалтын дараа бичил уурхайгаар[1] ашигт малтмал олборлосноос учирч болзошгүй нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ, үүнд: • Орон нутгийн хамтын ажиллагааны зөвлөлийн оролцоотойгоор холбогдох бүх сонирхогч талуудтай (бичил уурхайчдыг мөн оролцуулан) зөвлөлдсөний үндсэн дээр уурхайн хаалтын төлөвлөгөөг боловсруулах, түүнд нийгмийн	Байгаль орчны менежер Орон нутгийн харилцааны менежер Орон нутгийн харилцааны ажилтнууд	• Уурхайн хаалтын төлөвлөгөө • Уурхайн хаалтын нийгмийн асуудлаарх ажлын хэсэг (хурал, уулзалтын протокол, тэмдэглэл) • Оролцооны арга хэмжээнүүдийн бүртгэл (ОТТОТ).

[1] Зөвшөөрөлгүйгээр талбай руу нэвтрэн орох, хууль бусаар олборлолт хийхтэй холбоотой менежментийн арга хэмжээнүүдийг энд дурдав. 2015 оны сүүлээр өрнөсөн үлй явдлаас хойш энэ асуудлыг тусгайлан авч үзсэн болно.

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
			асуудлуудыг тусгах. Уг төлөвлөгөөг хаалтын үед хэрэгжүүлэхээс өмнө төслийн ашиглалтын үе шатанд урьдчилсан байдлаар боловсруулж ашиглалтын үе шатанд нарийвчлан боловсруулан шинэчлэнэ. • Хаалтын үеийн газрын хэлбэр, төрхийг бичил уурхайн олборлолтын өмнөх шатанд ямар байсан тэрхүү байдалтай нь дүйцүүлэн эсвэл нийцэхүйц болгох зураг төсөл, загвар гаргуулах үүднээс зохион байгуулалтад орсон бичил уурхайчид, мөн бусад сонирхогч талуудтай хамтран ажиллах замаар бичил уурхайчид уурхайн хаалтын төлөвлөгөөнд эзэн нь болж хэрэгжүүлэх явдлыг дэмжих.		
НМТ30	Хүн ам зүй	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Хаалтын нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ, үүнд: • Ургамалжуулах, төсөл хэрэгжих орон нутгийн иргэдийн хэрэгжүүлэх мод үржүүлгийн төслийн үйл ажиллагаа (Хүн ам зүй гэсэн хэсгийг үзнэ үү). • Хаалтын үр дүнд гарах эдийн засгийн эерэг үр ашиг, нөлөөг дээшлүүлэх (Эдийн засаг гэсэн хэсгийг үзнэ үү).	Байгаль орчны менежер Орон нутгийн харилцааны менежер Орон нутгийн харилцааны ажилтнууд	• Хаалтын менежментийн төлөвлөгөө.
НМТ31	Нийгмийн дэд бүтэц	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Боловсролын салбарт үзүүлэх нөлөөллийг удирдах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх, үүнд: • Хүний нөөцөд тавигдах нарийвчилсан шаардлагууд, төсөл хэрэгжих нийт хугацаа гэх мэт Гацууртын төслийн тухайн үеийн тусгайлсан шаардлагуудыг тусгах үүднээс сургалтын төлөвлөгөөг шинэчилнэ.	Хүний нөөцийн менежер Ханган нийлүүлэлтийн сүлжээ/худалдан авах ажиллагааны менежер	• Сургалт, хөдөлмөр эрхлэлтийн менежментийн төлөвлөгөө • Дотоод аудит, хяналтын хөтөлбөр • Тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлсэн тухай бүртгэл, тэмдэглэл

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
			• Барилга угсралт, олборлолтын чиглэлээр одоо ажиллаж байгаа чадварлаг боловсон хүчнийг татах, барилга, ашиглалтын туршлагатай, ирээдүйтэй ажилчдыг ажилд бэлтгэх сургалтаар хангах зорилгоор Мандал сум, Дархан, Эрдэнэт хотууд дахь МСҮТ-үүдтэй харилцаа холбоотой ажиллах, барилга, ашиглалт, хаалтын үе шатанд өсөл хэрэгжих орон нутагт харьяалалтай ажилчдад давуу эрх олгоно. • Төслийн хэрэгцээнд хамааралтай чиглэлээр сурах хэрэгцээг дэмжих тэтгэлэгт хөтөлбөр боловсруулах, тухайлбал төсөл хэрэгжих орон нутагт харьяалалтай, ялангуяа Түнхэл тосгоны сурах ирээдүйтэй төгөгчдөд голлон анхаарч барилга, ашиглалт болон хаалтын үе шатанд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх. • БГК-ийн хүний нөөц бүрдүүлэлтийн бодлогыг Хөдөлмөрийн тухай хууль, Монгол Улсын бусад хууль тогтоомж болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн салбарын тэргүүн туршлагад нийцүүлэх үүднээс хянан нягталж шинэчлэх • Төслийн зүгээс шаардлагатай сургалтын төлөвлөгөө, ур чадварт тавьж буй хэрэгцээг Төсөл хэрэгжих бүсэд амьдарч байгаа иргэдийн ур чадвартай харьцуулан судалсны үндсэн дээр юуны түрүүнд орон нутгийн иргэдээс ажилд авах боломжийг бүрдүүлэх. Ингэхдээ Төсөл хэрэгжих бүсээс нутгийн иргэд, тэр дундаа эмэгтэйчүүдийг ажилд авах зорилтын хэрэгжилтийг хянах.	Орон нутгийн харилцааны менежер Орон нутгийн харилцааны менежер Орон нутгийн харилцааны ажилтнууд	• Хүний нөөц бүрдүүлэлтийн бодлого • Оролцооны арга хэмжээнүүдийн бүртгэл (ОТТОТ).

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
			• Ашиглалтын үе шатанд салбарын тухай мэдлэг, туршлагаас суралцахад дэмжлэг үзүүлэх үүднээс ерөнхий боловсролын сургуулиуд, МСҮТ-үүд болон их, дээд сургуулиудтай харилцаа холбоотой ажиллах. • Сургалтын төлөвлөгөөг тасралтгүй хэрэгжүүлэхийн зэрэгцээ уг төлөвлөгөө Төслийн хэрэгцээ хангаж байгаа эсэхийг хянах, барилгын үе шатанд орон нутгийн иргэдээс түлхүү ажилд авах бодлого, тавьсан зорилтуудтай уялдуулах. • Хүний нөөцийн сургалтын (байгууллага дотроо болон гуравдагч байгууллагаас) үр нөлөөнд хяналт тавьж, шаардлагатай бол залруулах арга хэмжээ авах.		
НМТ32	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, харуул хамгаалалт	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Төслийн зүгээс эрүүл мэндийн үйлчилгээнд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх, үүнд: • Ажлын байран дээрх бэртэл гэмтэл, эрүүл мэндтэй холбоотой асуудал гарсан тохиолдолд СГМ-гийн бүх ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч нарыг орон нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцооноос тусдаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээр зохих түвшинд хангах; Уурхай дагасан иргэдийн шилжилт хөдөлгөөнөөс үүдэлтэйгээр орон нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үүсч болох нөлөөлөл, ачааллыг бууруулахын тулд Төслийн зүгээс орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад мөнгөн бус, тогтвортой хөрөнгө оруулалт хийх арга	Орон нутгийн харилцааны менежер Орон нутгийн харилцааны ажилтнууд Ханган нийлүүлэлтийн сүлжээ/худалдан авах ажиллагааны менежер Засгийн газартай харилцах асуудал хариуцсан менежер Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежер	• Ажиллагсдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын бүртгэл • Оролцооны арга хэмжээнүүдийн бүртгэл (ОТТОТ).

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
			замуудыг тодорхойлохын тулд орон нутгийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй зөвлөлдөж хамтран ажиллах;		
HMT33	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, харуул хамгаалалт	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Хөдөлмөрийн аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх, үүнд: • Компанийн болон гэрээт гүйцэтгэгчдийн ажилчдыг хөдөлмөр эрхлэлтийн эхний саруудад зааварчилгаа, сургалтаар хангаж, хяналт тавьж ажиллах. • Ажлын талбай, түүнтэй холбоотой аюул, эрсдлүүд, тухайн ажил үүргийнх нь хүрээн дэх эрсдэл, уг ажил үүргийг бүрэн гүйцэтгэхэд баримтлах ажлын талбайн арга, аргачлалыг сайтар эзэмшүүлэх үүднээс сургалтын процедур, ур чадвар шалган магадлах. • Шинэ ажил үүрэг, ажлын болон үйлдвэрийн тогтолцоонд эрсдлийн үнэлгээ хийх. • Гэрээний хугацаанд хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах хамгийн наад захын шаардлагыг гэрээт гүйцэтгэгчдэд тавьж ажиллах, зөрчил илэрсэн тохиолдолд арга хэмжээ авах, шийтгэл, хариуцлага хүлээлгэх. • Гэрээний эрх олгохын өмнөх урьдчилсан шалгаруулалт, шигших процессуудыг гэрээ байгуулахын өмнө хэрэгжүүлэх. • Зааварчилгаа, ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны талаар өдөр бүр хурал хийх, гэрээт гүйцэтгэгчдийн удирдлагатай хөдөлмөрийн аюулгүй	Орон нутгийн харилцааны менежер Орон нутгийн харилцааны ажилтнууд Ханган нийлүүлэлтийн сүлжээ/худалдан авах ажиллагааны менежер Засгийн газартай харилцах асуудал хариуцсан менежер Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежер	• Сургалтын бүртгэл • Сургалтын журам • Дотоод аудит, хяналтын хөтөлбөр • Эрсдлийн үнэлгээ хийсэн тухай бүртгэл • Гэрээт гүйцэтгэгчид хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын зөрчил гаргасан талаарх бүртгэл • Гэрээт гүйцэтгэгчдийг урьдчилан шалгаруулах, шигших ажиллагаа явуулса талаарх бүртгэл • Зааварчилгаа, ХАБ талаарх шуурхай уулзалт, менежментийн хурал зэргийг хамруулан гэрээт гүйцэтгэгчдийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьсан тухай бүртгэл • Хор аюулын лавлах материал дахь бүртгэл • Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө.

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
			байдлын талаар сар бүр хурал хийж гэрээний гүйцэтгэлд хяналт тавих. • Шинэ материалуудын Хор аюулын лавлах материалыг хөтлөх; ажилчдыг сургах, тухайлбал давтан сургалтад хамруулах, БИОИСЭЛДҮҮЛЭЛТИЙН® байгууламжид ажиллах ажилчдыг шинээр сургалтанд хамруулах, БИОИСЭЛДҮҮЛЭЛТИЙН® байгууламжид зориулан стандарт үйл ажиллагааны журмуудыг боловсруулах. • Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлах, шаардлага гарсан тохиолдолд байнгын сургалт зохион байгуулах.		
НМТ34	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, харуул хамгаалалт		Үйлдвэрлэлийн процесс, тоног төхөөрөмжийн эвдрэл, тэсэрч дэлбэрэх зэрэг тохиолдлын улмаас ноцтой бэртэл, гэмтэл авах, хүний амь үрэгдэх эрсдлийг бууруулахын тулд СГМ–ийн Бороогийн уурхай дээр хэрэгжүүлж ирсэн арга хэмжээнүүдийг Гацуурт төсөлд хэрэгжүүлнэ. Үүнд: • СГМ-гийн зүгээс боловсруулж баталсан Хямралын менежментийн төлөвлөгөө болон Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг Гацуурт төсөлд хэрэгжүүлж болох эсэхийг тодорхойлох. • Онцгой байдлын үеийн менежментийн төлөвлөгөөг (ОБҮМТ) нийтэд мэдээлж танилцуулах. • Онцгой тохиолдол, ослын үед авах хариу арга хэмжээний талаарх асуудлаар холбогдох байгууллагуудтай харилцаа холбоотой ажиллах.	Уурхайн менежер Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежер Орон нутгийн харилцааны менежер Орон нутгийн харилцааны ажилтнууд Ханган нийлүүлэлтийн сүлжээ/худалдан авах ажиллагааны менежер	• Хямралын менежментийн төлөвлөгөө болон Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө • Ил тод болговол зохих мэдээллээр хангасан тухай бүртгэл, тэмдэглэл, протокол • Онцгой тохиолдол, ослын талаар холбогдох байгууллагуудтай харилцаж ажилласан тухай бүртгэл • Цианидын менежментийн олон улсын кодын аудитын бүртгэл

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
			Компани цианид худалдан авах, тээвэрлэх, хадгалах, ашиглах, захиран зарцуулах ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн салбарын тэргүүн туршлагыг тууштай хэрэгжүүлэх үүднээс Цианидын менежментийн олон улсын кодыг цианидын үйлдвэрлэл, тээвэрлэлт, ашиглалтад үргэлжлүүлэн мөрдөнө.	Засгийн газартай харилцах асуудал хариуцсан менежер	
ННТ35	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, харуул хамгаалалт	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Барилга, ашиглалт, хаалтын үе шатанд Төслийн талбайн аливаа хэсэгт зөвшөөрөлгүй нэвтэрсний улмаас хүний эрүүл мэнд, амь насанд учрах аюул, эрсдлийг бууруулахын тулд Бороогийн уурхайд хэрэгжүүлж ирсэн эрсдэл бууруулах холбогдох арга хэмжээнүүдийг Гацууртын төсөлд хэрэгжүүлэх. Үүнд: • Тэсэлгээний нөлөөллийг бууруулах үүднээс олборлолт идэвхтэй явагдаж буй талбайгаас ард иргэдийг гаргах; • Иргэдийг зөвшөөрөлгүйгээр уурхайн талбай руу нэвтрэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор харуул хамгаалалтын ажилтнуудыг дайчлах; • Орох, гарах бүх цэгүүд дээр, түүнчлэн тодорхой давтамжтайгаар тусгай зөвшөөрөлтэй талбайн хилийн зурвас, хашаалсан хэсгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байршуулах; • Ажлын талбайд, мөн талбайн эргэн тойронд болон талбайн гаднах аюулгүй байдалтай холбоотой голлох асуудлуудын талаар мэдээлэл өгөхөөр оролцогч талуудтай байнга харилцаа холбоотой ажиллах хөтөлбөр хэрэгжүүлэх;	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежер Уурхайн менежер Орон нутгийн харилцааны менежер Орон нутгийн харилцааны ажилтнууд	• Дотоод аудит, хяналтын хөтөлбөр • Аюулгүй байдлын асуудлаар авч хэрэгжүүлсэн оролцооны арга хэмжээнүүдийн бүртгэл (ОТТОТ). • Ажлын талбайд ирсэн зочдын бүртгэл

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
			• Аулгүй байдал, хяналтыг хангаж зочдыг Төслийн талбайтай танилцуулах хөтөлбөр хэрэгжүүлэх.		
HMT36	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, харуул хамгаалалт	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Барилга, ашиглалтын үе шатанд халдварт өвчин гарах, тархах магадлалыг бууруулах үүднээс дараах арга хэмжээнүүдийг авах. Үүнд: • Ажиллагсад, гэрээт гүйцэтгэгчидтэй гэрээ байгуулахын өмнө болон гэрээний туршид тодорхой давтамжтайгаар эрүүл мэндийн үзлэгт хамруулах; • Ажилчдад зориулсан эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны зааварчилгаанд бэлгийн замаар дамжих болон бусад төрлийн халдварт өвчний талаар мэдээлэл өгөх, ийм төрлийн сургалтыг тогтмол зохион байгуулах; • Компанийн ажилчид, гэрээт гүйцэтгэгчдэд мэдээлэл өгөх, соён гэгээрүүлэх сургалтыг Төслийн талбайд ажиллаж буй эмч нарын багтай хамтран зохион байгуулах; • Бэлгийн замаар дамжих болон бусад төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд голлон чиглэсэн орон нутагт хэрэгжүүлж буй эрүүл мэндийн кампанит ажлыг дэмжих боломжуудыг тодорхойлох; • Ажилчдын кемпийн эргэн тойронд биеэ үнэлэх үйлдэлд оролцохыг хориглох бодлогыг чанд мөрдүүлэх;	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежер Хүний нөөцийн менежер Орон нутгийн харилцааны менежер Орон нутгийн харилцааны ажилтнууд	• Эрүүл мэндийн үзлэгийн бүртгэл • Зааварчилгааны бүртгэл • Ажлаас халсан ан ажилчдын бүртгэл

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
НМТ37	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, харуул хамгаалалт	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Төслийн зүгээс аюулгүй байдал, харуул хамгаалалттай холбоотойгоор гарч болзошгүй нөлөөллийг бууруулах үүднээс эрсдэл бууруулах дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд: • Төслийн үйл ажиллагааны улмаас нөлөөлөлд өртөх магадлалтай орон нутгийн иргэдтэй найрсаг харилцаа тогтооход Төслийн зорилго оршиж байдаг гэдгийг төслийн харуул хамгаалалтын албаны ажилтнуудад тайлбарлаж ойлгуулах, орон нутгийн иргэдийн саналаа илэрхийлэх, асуудлаа тавих өргөдөл, гаргах механизм хэрэгждэг тухай мэдээлэл өгөх; үүнээс гадна орон нутгийн иргэдтэй хүндэтгэлтэй харьцах, тэдгээрийг хүндлэх үүднээс харуул хамгаалалтын ажилтнуудыг хүний эрх, соёлын мэдрэмж, харилцааны ёс зүйн сургалтад хамруулах, тэдгээрт хяналт тавих. • Биеэ зөв авч явах, хүч хэрэглэх тохиолдолд хэрхэн хууль, журамд нийцүүлэн зөв зохистой авирлах талаар тоймлон тусгасан тусгайлсан агуулга бүхий харуул хамгаалалтын ажилтнуудад зориулсан ёс зүйн дүрэм боловсруулж хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах; “Сайн дурын зарчмууд”-ын хэрэгжилтэд аудит хийх. • Нөлөөлөлд өртсөн байх магадлалтай бүх талууд компанид хандан (Өргөдөл, гомдол барагдуулах журмын дагуу) хэрхэн өргөдөл, гомдол гаргах тухай иргэдэд мэдээлэх.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежер Орон нутгийн харилцааны менежер Орон нутгийн харилцааны ажилтнууд Хүний нөөцийн менежер Ханган нийлүүлэлтийн сүлжээ/худалдан авах ажиллагааны менежер	• Сургалтын бүртгэл • Хөдөлмөр эрхлэлт, сургалтын менежментийн төлөвлөгөө • Ёс зүйн дүрэм • Оролцооны арга хэмжээнүүдийн бүртгэл/ Өргөдөл, гомдол бүртгэх бүртгэл • Ажилчдын кемпийн дүрэм • Хяналт тавьсан харуул хамгаалалтын ажилтнууд.

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
			• Ажлын дундуур буюу ажиллах явцдаа орон нутгийн иргэдтэй харилцах явдлыг аль болох багасгах үүднээс ажилчдыг (барилга, ашиглалт, хаалтын үе шатанд ажиллах ажилчдыг оролцуулан) ажлын талбайд байрлах кемпэд байрлуулах. • Бодит бус мэдээлэлд дулдуйдан (Хүн ам зүй гэсэн хэсэгт дурдсанчлан) ажил хайх, бизнесийн эрэлхийлэх боломжийг бууруулах, ингэснээр орон нутгийн иргэдтэй зөрчилдөх магадлалыг хязгаарлах. • Ажлын талбайгаас бусад газар олон нийттэй таарах, харьцах магадлалыг бууруулах үүднээс ажиллагсад болон гэрээт гүйцэтгэгчдийн баримталбал зохих Ажилчдын кемпийн дүрмийг хэрэгжүүлэх; бусдыг хүндэтгэсэн, зохистой зан авир, үйл хөдлөлтэй байх шаардлагатайг ухамсарлуулан ойлгуулах, үүнийг амьдрал дээр хэрэгжүүлэхийн тулд сургалтад хамруулах. • Харуул хамгаалалтын албаны зохицуулалт, зохион байгуулалтыг Бороод хэрэгжүүлж байсны жишгээр хэрэгжүүлэх.		
НМТ38	Соёлын өв	Бүх үйл ажиллагаанд хамаарна	СГМ нь археологийн өв, үнэт зүйлд үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлэх дараах арга хэмжээнүүдийг боловсруулаад байна, тухайлбал: • Ажиллагсад болон гэрээт гүйцэтгэгчид түүх, соёлын өв, үнэт зүйлс бүхий газар нэвтрэх боломжийг хязгаарлах зорилгоор Бороогийн уурхай дээрх ажилчдын кемпэд байрлуулах.	Байгаль орчны менежер Орон нутгийн харилцааны менежер Хүний нөөцийн менежер	• Ажилчдын ёс зүйн дүрэм • Тохиолдлын олдворын тухайд баримтлах журам • Дотоод аудит, хяналтын хөтөлбөр.

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
			• Ажиллагсад болон гэрээт гүйцэтгэгчдийн ёс зүйн дүрэмд заасанчлан соёлын өв бүхий газар нутагт нэвтрэхийг хориглох. • Соёлын өв бүхий газар нутгаас хулгай хийх, эвдрэл, гэмтэл, хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор соёлын өвийн шинжээчдийн зөвлөснөөс бусад тохиолдолд, илэрсэн буюу тогтоогдоод байгаа түүх, соёлын өв, үнэт зүйлсийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл нийтлэхээс аль болох зайлсхийх. • Уурхайд ажилладаг ажилчин бүр археологийн ямарваа олдвортой санаандгүй таарсан тохиолдолд ажлаа нэн даруй зогсоож шалгах, томоохон олдвор оршин байж мэдэх газрын орчим дахь ажлаа зогсоож, холбогдох эрх бүхий байгууллагуудад мэдэгдэх зэрэг шаардлага бүхий “Санамсаргүй олдворын журам”-ыг хэрэгжүүлэх. • Өмнө нь илэрсэн аливаа соёлын биет өвийг хөндөхөөр бол ШУ-ны Академийн Археологийн хүрээлэнд мэдэгдэж энэ талаар зөвлөлдөх.	Орон нутгийн харилцааны ажилтнууд Хэвлэл мэдээллийн харилцаа хариуцсан менежер	
НМТ39	Соёлын өв		Соёлын биет бус өвд нөлөөлөл үзүүлэх магадлалыг бууруулах үүднээс Төслийн зүгээс дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ, үүнд: • Түүх, соёлын дурсгалт зүйлсийн талаарх орон нутгийн иргэдийн зан заншил, өв, үнэт зүйлс бүхий газар нутгуудад эвдрэл, гэмтэл, хохирол учруулах, үл хүндэтгэх магадлалыг бууруулах үүднээс тухайн чиглэлээр мэдлэг, мэдээлэл сайтай уугуул	Байгаль орчны менежер Орон нутгийн харилцааны менежер Орон нутгийн харилцааны ажилтнууд	• Зааварчилгааны бүртгэл • Худалдан авалтын бүртгэл • Оролцооны арга хэмжээнүүдийн бүртгэл// Өргөдөл, гомдол бүртгэх бүртгэл • Орон нутгийн соёлын арга хэмжээнд үзүүлсэн дэмжлэгийн тухай бүртгэл

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
			иргэдийн хувь нэмэртэйгээр орон нутгийн соёлын талаар мэдээлэл өгөх сургалтын хөтөлбөр боловсруулж, бүх ажиллагсад, гэрээт гүйцэтгэгчдийг хамруулах. • Орон нутгийн иргэдийн тахин шүтдэг газарт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлохоос зайлсхийх. • Төсөл хэрэгжих бүхий л үе шатанд Гацууртын тээврийн зам дагуух түүх, соёлын дурсгал бүхий газарт чөлөөтэй очих боломжийг хязгаарлахгүй байхад анхаарах. • Орон нутгийн иргэд, оролцогч талуудтай байнга харилцаа холбоотой ажиллах, тэдний оролцоог хангах үүднээс оролцогч талуудыг татан оролцуулах, гомдол барагдуулах үйл явцыг бий болно. Үүний дагуу мал аж ахуй эрхлэх, мал бэлчээх уламжлалд, түүнчлэн уг уламжлалын амин чухал хэсэг болох бэлчээр, усны эх үүсвэрт үзүүлэх аливаа нөлөөллийг багасгахад чиглэсэн эрсдэл бууруулах арга хэмжээ, мөн төслийн зүгээс үзүүлэх нөлөөлөл, бэлчээр сайжруулах хөтөлбөрт голлон анхаарна (Газар ашиглалт гэсэн хэсгийг мөн үзнэ үү). • Цаашилбал, орон нутгийн иргэдийн соёлын арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх, нутгийн уламжлал, соёлыг хадгалан хамгаалах, сэргээх үүднээс төслийн зүгээс сумын захиргаа, олон нийтийн бүлгүүдтэй хамтран ажиллана.	Хэвлэл мэдээллийн харилцаа хариуцсан менежер	• Дотоод аудит, хяналтын хөтөлбөр • Нийгмийн суурь үнэлгээнд хийх байнгын хяналт-шинжилгээний тайлан

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
			• Биет бус соёлын өв нөлөөнд өртсөн нь хяналтаар тогтоогдсон, эсвэл ирээдүйд сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй хэмээн иргэд сэтгэл зовниж буйгаа илэрхийлсэн тохиолдолд эдгээр нөлөөллийг бууруулахын тулд эрсдэл бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Соёлын өв, үнэт зүйлсийн талаарх орон нутгийн иргэд мэдлэг, чадавхи дутмаг байвал орон нутгийн байгууллагуудын зүгээс иргэдэд мэдээлэл түгээх, боловсрол олгох чадавхийг нь дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээнүүд энд орно. СГМ компанийн зүгээс төсөл хэрэгжих газар нутгийн ард олны аман түүхийг хадгалж хамгаалах үүднээс хууч яриа, аман түүхийн хөтөлбөрийг сумын соёлын төвд түшиглэн бий болгох, нутгийн иргэдэд биет болон биет бус соёлын өвийн талаар мэдээлэл өгөх олон нийтийн хөтөлбөр боловсруулах, үзмэрүүд бэлтгэх.		
НМТ40	Бичил уурхайчид	Бүх үйл ажиллагаанд хамаарна	Гол түншүүд, мөн Монголын бусад оролцогч талуудтай хамтран Стратегийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах (үүнийг баталгаажуулна), үүнд: • **Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх:** ○ Нийгмийн / аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ хийж шинэчлэх; ○ Зөвшөөрөлгүйгээр лицензийн талбай руу нэвтрэн орох, хууль бусаар олборлолт хийх үзэгдлийн үндсэн учир шалтгаан, нийгэмд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж судлах;	Аюулгүй байдлын албаны менежер Орон нутгийн харилцааны менежер; Орон нутгийн харилцааны ажилтнууд Хэвлэл мэдээллийн харилцаа хариуцсан менежер Хөдөлмөрийн аюулгүй байдал,	• Тогтмол шинэчлэгдэх нийгмийн эрсдлийн үнэлгээ. • Гол оролцогч талуудтай зөвлөлдсөн, харилцаа

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
			○ Цагдаа, шүүхийн байгууллагатай хамтран одоогийн хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцох арга хэмжээнүүдэд үнэлгээ хийх; ○ Гол оролцогч талуудтай хамтран мэдээлэл цуглуулах сүлжээ, протокол бий болгох. • **Харилцаа холбоо, иргэдэд таниулан сурталчлах:** ○ Зөвшөөрөлгүйгээр лицензийн талбай руу нэвтрэн орох, хууль бус гар аргаар олборлолт хийхээс иргэдийг урьдчилан сэргийлэх үүднээс олон нийтэд чиглэсэн боловсролын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх; ○ Хууль бус арга хэмжээнд оролцохоос үүдэх эсдлийн талаар БГК-ийн бүх ажилчдад мэдлэг олгох, соён гэгээрүүлэх хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх; ○ Хууль биелүүлэх, иргэдийн оролцоотой цагдаагийн эргүүлийн тухай ойлголт өгөх, соён гэгээрүүлэх зорилгоор сумын захиргаа, цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах; ○ БГК-ийн өргөдөл, гомдол гаргах журмын талаар иргэдийн ойлголт, мэдлэгийг судалж дахин мэдээлэл хүргэх, Орон нутгийн харилцааны хэлтсийн нийт ажилтнууд хүний эрх зөрчигдсөн гэх гомдлын тухай бүрэн ойлголттой болох, энэ тухай дотооддоо хэрхэн мэдэгдэхэд анхаарч ойлголтыг нь сайжруулах.	эрүүл ахуйн менежер Уурхайн менежер Засгийн газартай харилцах асуудал хариуцсан менежер	холбоотой ажилласан тухай тэмдэглэл, бүртгэл. • • • • • Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, тэмдэглэл. • Өргөдөл гомдлын бүртгэл

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
			• **Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагуудтай зөвлөлдөх:** ○ Орон нутаг дахь олон нийтийн аюулгүй байдлыг сайжруулахын тулд кампанит ажил явуулах, дэмжлэг туслалцаа/ нөөц хайх үүднээс Монгол Улсын Засгийн газартай бүхий л түвшинд хамтран ажиллах (үр дүнтэй олон нийтийн цагдаагийн эргүүлийн загварыг оролцуулан); ○ Бичил уурхай, хууль бус олборлолтыг зохицуулах Засгийн газрын эрх үүргийг бүхтүвшинд үр дүнтэй хэрэгжүүлэхэд бүхий л шугамаар дэмжлэг үзүүлэх; ○ бичил уурхайчдыг зохион байгуулалтад оруулах, том хэмжээний уурхайтай зэрэгцэн оршихтой холбоотойгоор дэлхийн улс орнуудад гарч буй сорилтын талаарх Засгийн газар (болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл)-ын ойлголтыг нэмэгдүүлэх; ○ Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох зохицуулалтыг албажуулах зорилгоор Засгийн газарт дэмжлэг үзүүлэх, түншлэх боломжуудыг эрэлхийлэх (2014 оны Ашигт малтмалын тухай хууль, 2010 оны бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам); ○ Бичил уурхайн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд/хандивлагч байгууллагуудтай түншлэх боломжийг эрэлхийлж түүнд үнэлгээ хийх, тухайлбал Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ),		• Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагуудтай хийсэн зөвлөлдөх арга хэмжээнүүдийн бүртгэл. • Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон мэдлэг дээшлүүлэх материал / кампанит ажлын тайлан, бүртгэл

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
			Азийн сан, Швейцарийн хөгжлийн агентлаг (Тогтвортой бичил уурхай (SAM) төсөл)-ийг энд дурдаж болно. • **Таслан зогсоох үр дүнтэй арга хэмжээ авах:** ○ Аюулгүй байдлын албанд мөрдөх стандарт үйл ажиллагааны журам, тактик, сургалт, тоног төхөөрөмж, нөөцөд үнэлгээ хийх, шаардлагатай бол зохих арга хэмжээ авах; ○ Цагдаагийн байгууллагатай байгуулсан Хамтын ажиллагааны гэрээ (ХАГ)-г хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих; ○ Эрт анхааруулах систем болгон ашиглах, нотлох баримт цуглуулах үүднээс одоо хэрэгжүүлж байгаа ажиглалт, бичлэг хийх аргууд (жишээ нь CCTV, дрон, гэрэл зураг, эргүүл, ажиглалтын цамхаг гэх мэт)-ыг сайжруулах хувилбаруудад үнэлгээ хийх; ○ Хашаа, бусад саад тотгор, зохих тэмдэг тэмдэглэгээ ашиглах замаар лицензийн талбайн заагийг тодорхой, сайн харагдахаар тэмдэглэх (хяналтын болон орчны бүсийн хэмжээсийн тойрог байгуулах). • **Хариу арга хэмжээ авах:** ○ Болзошгүй аюул заналын үед хариу арга хэмжээ авах нөөцөөр харуул хамгаалалтын ажилтнуудыг хангах, тухайлбал удирдамж, тоног төхөөрөмж (хувийн хамгаалалтын хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгсэл, тусгай		• Стандарт үйл ажиллагааны журам, тактик, сургалт, тоног төхөөрөмж, нөөцөд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний бүртгэл • Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ • Ажиглалт, бичлэг хийх аргуудыг сайжруулахын тулд үнэлгээ хийсэн тухай тэмдэглэл тогтолцооны талаар бэхжүүлэх сонголтуудын үнэлгээ тэмдэглэл • Периметрийн дагуу хамгаалах төлөвлөгөөний хяналт-шинжилгээ. • Сургалтын арга хэмжээнүүдийн бүртгэл; • Аюулгүй байдалтай холбоотой зөрчил дутагдлыг дотооддоо тайлагнах.

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэгжүүлэх хүрээ/ үйл ажиллагаа	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Шалган магадлах арга хэрэгсэл
			хэрэгсэл гэх мэт)-өөр хангах, хүн хүч нэмэгдүүлэх, тусгай хэрэгслээр хангах; ○ Хуулийн хүрээнд хүч болон тусгай хэрэгсэл хэрэглэх зэргээр болзошгүй аюул занал гарсан тохиолдолд хариу арга хэмжээ авах талаар харуул хамгаалалтын ажилтнуудыг сургах, хээрийн түвшний эрсдлийн үнэлгээ хийх гэх мэт; ○ Аюулгүй байдлын ноцтой зөрчил гэдгийг тодорхойлох, үүнийг нэн даруй дотооддоо (болон Цагдаагийн байгууллагад) мэдээлэх, шуурхай арга хэмжээ авах (мөн ийм зөрчил гарсан тохиолдолд Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг хянан үзэж); ○ Олон улсын хүний эрхийн зарчмууд, тэр дундаа Аюулгүй байдал, хүний эрхийн талаарх сайн дурын зарчмуудад тусгагдсан хүний эрхийг дээдлэх зарчмыг аюулгүй байдлыг хангах бүхий л үйл явц, үйл ажиллагаанд чанд сахин мөрдөх; ○ БГК-ийн бүх ажиллагсад, мөн аюулгүй байдлыг хангахаар сайтад байрлах холбогдох төрийн байгууллагын ажилтнуудыг хүний эрхийн сургалтанд хамруулах.		• Онцгой байдлын үед авах үйл ажиллагааны төлөвлөгөөг тогтмол хянаж үзсэн тухай тэмдэглэл. • Аюулгүй байдал, хүний эрхийн талаарх сайн дурын зарчмуудын хэрэгжилтэд тогтмол аудит хийх

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

6 ХЭРЭГЖИЛТИЙН ХУВААРЬ

6.1 Менежментийн төлөвлөгөөг хянан нягталж, шинэчлэх

Энэхүү Менежментийн төлөвлөгөөг жил бүр хянан нягтлахын зэрэгцээ Гацууртын нөхцөл байдал, хэрэгцээ өөрчлөгдвөл тусгах зорилгоор шаардлагатай шинэчлэлтийг оруулна. Төлөвлөгөөг хянан шинэчлэх нь түүнийг мэдэлдээ байлгаж буй Байгаль орчны асуудал эрхэлсэн захирлын үүрэг хариуцлага мөн.

Үйл ажиллагааны процедурт томоохон өөрчлөлт оруулах шаардлага үүсвэл Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгль орчны менежментийн системд (ЭМААБОМС) заасан Өөрчлөлтийн менежментийн журамд тусгагдсаны дагуу шинэчилж болно.

7 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ

7.1 Хяналт-шинжилгээний шаардлагуудын тойм

Төслийн стандартуудад нийцэж буй байдалд нь үнэлгээ хийх үүднээс олборлолтын үе шатанд хэрэгжүүлэх хяналтын арга хэмжээнүүдийг энэ бүлэгт тодорхойлов (“Төслийн стандартууд” гарчигтай IV бүлгийг үзнэ үү).

Төслийн стандартуудад нийцэхгүй байгаа нь хяналтын ажиллагаагаар тогтоогдсон тохиолдолд түүний мөрөөр шалгаж, зохих залруулгын арга хэмжээг тодорхойлсны дагуу авч хэрэгжүүлнэ.

7.2 Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд

Доорх хүснэгтэд гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг, түүнчлэн эрсдэл бууруулахаар санал болгож буй стратегиудын ахиц явц, үр дүнд үнэлгээ хийхэд ашиглаж болох хяналтын гол арга хэмжээг хураангуйлан тусгав.

Хүснэгт 3: Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт ба хяналтын арга хэмжээ

Лавлах дугаар	Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт	Зорилтот түвшин	Хяналт-шинжилгээний арга хэмжээ
НМТ-ГҮҮ 01	Энэхүү Менежментийн төлөвлөгөөнд тодорхойлсон эрсдэл бууруулах хяналтыг мөрдөөгүй мэдээлийн тоо.	Зорилт: Тэг Мөрдөөгүй талаар тайлагнасан тохиолдлын тоог доод түвшинд хүргэж бууруулах, лавшруулан сайжруулах	Дотоод аудитын дүн
НМТ-ГҮҮ 02	Орон нутгийн иргэдээс гаргасан өргөдөл, гомдол барагдуулахад зарцуулсан хугацаа	Зорилт: гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор мэдэгдэх; гомдлын мөрөөр ажлын 14 өдрийн дотор арга хэмжээ авч, баримтжуулах.	Өргөдөл, гомдлын бүртгэл, авсан арга хэмжээ
НМТ-ГҮҮ 03	Орон нутгийн харилцаа хариуцсан ажилтнуудын энэхүү Төлөвлөгөөний шаардлагуудын талаарх мэдлэг, ойлголт	Зорилт: Орон нутгийн харилцаа хариуцсан ажилтнуудын 90%-ийг нийгэмд нөлөөлөх байдлын менежментийн төлөвлөгөөний шаардлагууд, хэрэгжилтийн талаар сургалтад хамруулах	Сургалтын бүртгэл

8 СУРГАЛТ

СГМ-гийн бүх ажиллагсад, Гацууртын төсөлд сонгогдсон гэрээт гүйцэтгэгчдийн бүх ажиллагсад нийгмийн нөлөөллийн менежментэд хамаарах асуудлаар сургалтанд хамрагдсан байх шаардлагатай (дээрх Хүснэгт 2-ыг үзнэ үү).

Сургалтын арга хэмжээний бүртгэл хөтөлж хадгална.

9 АУДИТ БА ТАЙЛАГНАЛ

9.1 Дотоод аудит

Үйл ажиллагааны нэгжүүдийн ахлах ажилтнууд нийгмийн нөлөөллийн менежментийн хэрэгжилтэд дотоод аудит, тогтмол хяналт тавьж ажиллана.

Аудит болон хяналтаар илэрсэн бүхий л зөрчлийг БГК-ийн ХАБЭАБОМТ-ны шаардлагуудын дагуу мэдээлж тайлагнана.

9.2 Хөндлөнгийн аудит

БГК-ийн ХАБЭАБОН-ийн аудитын хөтөлбөрийн хүрээнд болон Зээлдүүлэгчдийн зүгээс энэхүү төлөвлөгөөний биелэлтэд тогтмол аудит хийнэ.

9.3 Бүртгэл, тэмдэглэл хөтлөх

Аудитын шалгалт, үзлэг, зөрчил дутагдлыг БГК-ийн ХАБЭАБОМТ-ны журмын тэмдэглэж бүртгэл хөтөлнө.

ХЭВЛЭГДСЭН ДАРУЙД ХЯНАЛТААС ГАРАХ ХУВИЛБАР. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ КОМПАНИЙН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.